


Ашигт малтмалын газрын газрын  
2011 оны 1-р сарын 27-ны өдрийн 2 дугаар  
1 дүгээр хавсралт



АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН НҮҮРСНИЙ ХЭЛТЭСНИЙ  
“АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙД ГҮЙЦЭТГЭХ УУЛЫН  
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХҮЛЭЭН АВАХ” ДОТООД ЗААВАР

Нүүрсний хэлтэс нь Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.2-д заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс доор дурдсан шаардлагыг хангасан уулын ажлын төлөвлөгөөг хүлээн авсан байна. Үүнд:

1. Уулын ажлын төлөвлөгөөг тухайн уурхай болон ордын хүрээнд батлагдсан Техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан нэг жилийн хугацаагаар боловсруулж, түүнд гүйцэтгэх ажлын төрөл, тоон хэмжээ, эдийн засгийн үзүүлэлтүүдийг задалж тооцсон байна.
2. Уулын ажлын төлөвлөгөө нь ерөнхий мэдээлэл, ордын геологи, ордын нөөцийн ашиглалт, уурхайн ашиглалтын технологи, ажиллах горим, нүүрсний баяжуулалт, боловсруулалтын технологи, уурхайн хаягдлын аж ахуй, уурхайн ус таталт ба усан хангамж, уурхайн цахилгаан хангамж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажил, эдийн засгийн тооцоо гэсэн үндсэн бүлгүүд, холбогдох маягт, хавсралт материал болон зургуудаас бүрдэх бөгөөд Монгол хэлээр, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 1-р сарын 27-ны өдрийн 2 дугаар тогтоолоор баталсан Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг MNS 5140-(1:3)-2011 стандартын дагуу боловсруулагдсан байна.
3. Уулын ажлын төлөвлөгөөний геологийн болон нөөцийн дэвсгэр зураг, уурхайн ерөнхий дэвсгэр зураг, ил уурхайн гадаад траншейн дэвсгэр зураг ба түүний дагуу, хөндлөн зүсэлтүүд, хөрс ба олборлолтын доголдуудын ажлын талбайн бүтцийн дэвсгэр зураг тэдгээрийн зүсэлтүүд, далд уурхайн нээгч, бэлтгэл, цэвэрлэгээний малталтуудын аффин проекц, тэдгээрийн дагуу буюу хөндлөн огтлолууд, өрөмдлөг тэсэлгээний ажлын болон бэхлэгээний паспортууд ус таталтын технологийн схем, үйлдвэрийн технологийн ус хангамжийн схем, эргэлтийн болон зайлуулж байршуулах усан сангийн дэвсгэр зураг, шимт хөрсний овоолго, эвдрэлд өртөх болон нөхөн сэргээх талбайн дэвсгэр зураг, мөн техник технологийн паспортуудыг Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 12-р сарын 16-ны өдрийн 77 дугаар тогтоолоор баталсан Уул уурхайн график, зураг, бичиг баримтын төрөл ба иж бүрдэл MNS 6302-(1:8) : 2011 стандартын дагуу гүйцэтгэсэн байна.

*Ерөнхий мэдээлэл бүлэг-т*

Ордын газарзүй, байршил, бүс нутгийн үйлдвэржилт, хэтийн төлөв дэд бүтцийн хөгжил (эрчим хүч, дулаан ба ус хангамж, зам харилцаа), агаарын хэм, салхи, хур тунадас зэрэг байгаль цаг уурын нөхцөл, олон жилийн цэвдэг, улирлын хөлдөлтийн хэмжээ, хугацаа, гадарга ба ус зүйн нөхцлийн талаар тусгасан байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар, улсын даалгавар, захиалга, аж ахуйн гэрээ болон зааврын маягт 1.1-ийг тодорхой бүрэн бүрдүүлж тусгасан байна.

### *Ордын геологи бүлэг-т*

Ордын судлагдсан байдал, ордын геологийн тогтоц, тектоникийн үзүүлэлтүүд, давхарга зүй, нүүрсний давхаргуудын тоо, зузаан, чанарын үзүүлэлтүүд чулуулгийн физик-механикийн шинж чанар, гидрогеологийн нөхцлийн талаар тодорхой тусгасан байна.

Ашигт малтмалын нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн баримтын хуулбар, геологийн болон нөөцийн дэвсгэр зураг (M1:100000, M1:5000, M1:2000), дагуу ба хөндлөн зүсэлтүүд (M1:5000, M1:2000, M1:1000)-ийг хавсаргасан байна.

### *Ордын нөөцийн ашиглалт бүлэг-т*

Ордын ашиглалтанд хамрагдах блокын нөөцийн тооцоо, хаягдал ба бохирдолт, тооцсон хувь, хэмжээ чанарын үзүүлэлтүүд, бүтээгдэхүүн гаргалт, экспортлохоор төлөвлөж байгаа болон дотооддоо нийлүүлэхээр төлөвлөж байгаа зэргийг тусгасан байна. Зааврын маягт 1.6-ыг хавсаргасан байна.

### *Ордын нүүрсний чанар бүлэг-т*

Ордын ашиглалтанд хамрагдах блокын нүүрсний чанарын үзүүлэлтүүд, борлуулах нүүрсний хэрэглээний зориулалтаар экспортын түүхий нүүрс, экспортын баяжуулсан нүүрс, Эрчим хүчний баяжуулсан /завсарын/ нүүрс, дотоодын эрчим хүчний нүүрс, орон нутгийн дулааны хангамжийн нүүрсний дээжлэлт, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ, шинжилгээний үр дүн зэргийг тусгасан байна. Зааврын маягт 1.7-ыг хавсаргасан байна.

### *Нүүрсний уурхайн ашиглалтын технологи, ажиллах горим бүлэг-т*

Ашигт малтмалын ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг баримтлан ашиглалтын систем, технологийн дагуу хийж гүйцэтгэх ажлыг дараах байдлаар тусгана.

1. Ил уурхайн тухайн оны нээгч, бэлтгэл болон үндсэн малталт, хөрс хуулалт, олборлолтын оновчтой хэмжээ, өрөмдлөг тэсэлгээ, ухаж ачих ажиллагаа, тээвэрлэлт, овоолгын аж ахуй /шимт хөрсний овоолго, хөрсний гадаад болон дотоод овоолго, овоолгын шатлалт, түүнийг гулсалтаас хамгаалах арга хэмжээ/-н ажлуудын уялдаа, механикжуулалтын бүтэц, шаардагдах тоног төхөөрөмжийн тоо, бүтээл, материалын тооцоо, уурхайн замын ерөнхий схем, уулын ажлын календарь төлөвлөгөө, үйлдвэрлэлийн процессуудын технологи, зохион байгуулалтыг тусгана. Уурхайн ерөнхий дэвсгэр зураг (M1:10000, M1:5000, M1:2000, M1:1000), ил уурхайн гадаад траншейн дэвсгэр зураг ба түүний дагуу, хөндлөн зүсэлтүүд (M1:2000, M1:1000), хөрс ба олборлолтын доголлуудын ажлын талбайн бүтцийн дэвсгэр зураг тэдгээрийн зүсэлтүүд (M1:500, M1:200), өрөмдлөг тэсэлгээ, ухаж ачих ажиллагаа, овоолгын ажлын технологийн паспортууд, маягт 1.5, 1.10-ыг хавсаргасан байна.

2. Далд уурхайн тухайн оны үндсэн, бэлтгэл, цэвэрлэгээний малталтын ажлын хэмжээ, уулын даралт, уурхайн агааржуулалт, өрөмдлөг

тэсэлгээ, ачих, тээвэрлэх, бэхэлгээний ажлын тооцоо, хоорондын уялдаа, механикжуулалтын бүтэц, шаардагдах тоног төхөөрөмжийн тоо, бүтээл, материалын тооцоо, уулын ажлын календарь төлөвлөгөө, үйлдвэрлэлийн процессуудын технологи, зохион байгуулалтыг тусгана. Уурхайн ерөнхий дэвсгэр зураг (M1:10000, M1:5000), далд уурхайн нээгч, бэлтгэл, цэвэрлэгээний малталтуудын аффин проекц, тэдгээрийн дагуу буюу хөндлөн огтлолууд, өрөмдлөг тэсэлгээний ажлын болон бэхэлгээний паспортууд, маягт 1.5, 1.10-ыг хавсаргасан байна.

*Нүүрсний баяжуулалт, боловсруулалтын технологи, уурхайн хаягдлын аж ахуй бүлэг-г*

Баяжуулах үйлдвэр (цех)-ийн хүчин чадал, ажиллах горим, эрдсийн баяжуулалтын технологи, технологийн схемийн тоо-чанарын үзүүлэлтийн тооцоо, ашиглагдах тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн тоноглолын түвшин, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт, ажлын тооцоо, реагент бодисын хэрэгцээ, нэршил, химийн томъёо, төрөл, хэмжээ, үндсэн үзүүлэлт, орц, найрлага, хангамжийн эх үүсвэр, гэрээлэлтийн асуудал, ашиглалтын явцад дайвар ашигт малтмалыг зүй зохистой ашиглах, боловсруулах, хадгалах, хамгаалах арга хэмжээ, үйлдвэрийн хаягдал дахь ашигт болон хортой элементийн агуулгын хэмжээ, ус-шлагын схемийн тооцоо, хаягдлын аж ахуйн бүтэц, зохион байгуулалтын талаар тусгасан байна.

Баяжуулалтын технологийн тоо-чанарын болон ус-шлагын схем, хаягдлын аж ахуйн дэвсгэр зураг түүний зүсэлтүүд, үзүүлэлтүүдийг маягт 1.12-ын дагуу боловсруулсан байна.

*Уурхайн ус таталт ба усан хангамж бүлэг-г*

Ус шүүрүүлэх /зайлуулах/ арга, уурхайд орж ирэх усны хэмжээ, ус татагч тоног төхөөрөмж, ус таталтын тооцоо, хуримтлуулах болон үер борооны уснаас хамгаалах арга хэмжээ, үйлдвэрийн усны хэрэглээ, эх үүсвэр, эргэлтийн усан сан, түүний хангамжийн тооцоо, шаардагдах тоног төхөөрөмжийн тооцоог тусгана.

Ус таталтын технологийн схем, үйлдвэрийн технологийн ус хангамжийн схем (M1:5000, M1:2000, M1:1000), эргэлтийн болон зайлуулж байршуулах усан сангийн дэвсгэр зураг (M1:500, M1:200)-ийг, үзүүлэлтүүдийг маягт 1.11-ын дагуу боловсруулж хавсаргасан байна.

*Уурхайн цахилгаан хангамж бүлэг-г*

Уурхайн цахилгаан хангамжийн эх үүсвэр, шаардлагатай эрчим хүчний хэмжээ, эрчим хүчний хэрэглээний тооцоо, дэд станц, хуваарилах байгууламж, бууруулах станцын чадал, цахилгаан дамжуулах шугам, реле хамгаалалт, газардуулга, уурхайн мөргөцөг, зам, талбай, овоолгын гэрэлтүүлгийн схемийг тусгасан байна.

Уурхайн цахилгаан хангамжийн схемийг (M1:5000, M1:2000) хавсаргасан байна.

*Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүлэг-г*

Ил болон далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрмүүдийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ, тэсрэх материалын хадгалалт хамгаалалт, тэсэлгээний ажлын зохион байгуулалт, аюулгүйн нөхцлийг хангах асуудал, гал түймрийн аюул, нурал, гулсалтаас урьдчилан сэргийлэх ажиллагаа, хий тоосны хэмжилт, ажиллагсдын эрүүл ахуй, эрүүл мэндийн үйлчилгээ, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн зориулалттай тоног төхөөрөмж холбогдох зардлын тооцоог тусгана.

Уурхайн агааржуулалтын тооцоо, гэрэлтүүлгийн схем, Уул уурхайн аврах албаар батлагдсан “Аваарь устгах төлөвлөгөө”, тэсэлгээний ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар, тэсэлгээний ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар тэсэлгээний ажил гүйцэтгүүлэх хоорондын гэрээний хуулбар, тэсэлгээний үнэмлэхний хуулбар, маягт 1.13.1, 1.13.2-ыг иж бүрэн, тодорхой боловсруулж хариуцах албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

#### *Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх ажил бүлэг-т*

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг баримтлан тухайн жилд эвдрэлд өртөх талбай, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын хэмжээ, шаардагдах зардлын тооцоог тусгана. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг батлуулсан байна.

Шимт хөрсний овоолго, эвдрэлд өртөх болон нөхөн сэргээх талбайн дэвсгэр зураг (M1:2000, M1:1000), маягт 1.8-ыг бүрдүүлнэ. Дэвсгэр зурагт шимт хөрсний овоолгын өндөржилт метрээр, хамрах талбайн хэмжээг га-аар тооцсон байна.

#### *Эдийн засгийн тооцоо бүлэг-т*

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болох хөрөнгө оруулалт, борлуулалтын орлого, ашигт малтмалын үнэ, нийт болон үйлдвэрлэлийн зардал (улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөрийг тусад нь үзүүлэх), улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр, борлуулалтын орлого, үйлдвэрлэлийн болон удирдлагын зардал, нэгж бүтээгдэхүүний борлуулалтын үнэ, нэгж бүтээгдэхүүний өөрийн өртөг, татварын өмнөх ашиг, ААНБОАТ, татварын дараах цэвэр ашиг, мөнгөн урсгалыг тусгаж, маягт 1.2, 1.3, 1.4, 1.9-ыг бүрдүүлсэн байна.

1. Уулын ажлын төлөвлөгөөнд хавсаргах зургийн масштабыг уулын ажлын ашиглалтын системийн элементүүдийг ялган харж болохуйцаар сонгож боловсруулна.

2. Уулын ажлын төлөвлөгөөг зохиоход ашигласан тайлан, материалын жагсаалтыг хавсаргана.

3. Уулын ажлын төлөвлөгөөг боловсруулсан инженер техникийн болон санхүүгийн холбогдох ажилтнууд нь гарын үсгээ зурж, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн удирдлага нь баталгаажуулсан байна.

4. Уулын ажлын төлөвлөгөө, тайлан хариуцсан мэргэжилтэн ирүүлсэн Уулын ажлын төлөвлөгөөг НХ-ийн дарга болон НХ-ийн ҮТТ-ийн даргад танилцуулж, зөвшөөрсний дараагаар, бүртгэлийн дэвтэрт бүртгэн авч дугаарлан, хяналтын хуудас нээн, төлөвлөгөөг авчирсан албан тушаалтанаар гарын үсэг зуруулж, хуваарилагдсан мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

5. Уулын ажлын төлөвлөгөө, тайлан хариуцсан мэргэжилтэн нь хүлээн авсан уулын ажлын төлөвлөгөө, тайлангийн хуваарилалт, гүйцэтгэлд хяналт тавих, аж ахуйн нэгжүүдэд тайлбар өгөх, холбогдох мэргэжилтнүүдтэй цагийн хуваарийн дагуу уулзуулах, албан бичгээр хариу өгөх, зөвшөөрөгдсөн Уулын тайлан төлөвлөгөө, тайланг хүлээлгэн өгөх ажлуудыг гүйцэтгэнэ.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн уулын ажлын төлөвлөгөөний ерөнхий мэдээлэл бүлэг, *уулын ажлын тайлан, төлөвлөгөө, хариуцсан мэргэжилтэн*, ордын геологи, ордын нөөцийн тооцоо бүлгийг *нөөцийн хөдөлгөөн хариуцсан мэргэжилтэн*, ордын нүүрсний чанар бүлгийг *нүүрсний чанар, стандартчиллын судалгаа хариуцсан мэргэжилтэн* эдийн засгийн тооцоо бүлгийг *салбарын эдийн засаг, үнэлгээний судалгаа хариуцсан мэргэжилтэн*, тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөний үндсэн үзүүлэлт, уурхайн ашиглалтын технологи, ажиллах горим, уурхайн цахилгаан хангамж, уурхайн ус таталт ба усан хангамж бүлгийг *техник технологи хариуцсан мэргэжилтэн*, нүүрсний баяжуулалт, боловсруулалтын технологи, уурхайн хаягдлын аж ахуй бүлгийг *нүүрсний баяжуулах үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн*, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажил бүлгийг *байгаль орчны нөхөн сэргээлт хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн*, улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажил, нөхөн төлбөрийн хэмжээг *хайгуулын ажлын нөхөн төлбөр, гэрээлэлт хариуцсан мэргэжилтэн* тус тус танилцсаны дараа *үйлдвэрлэл технологийн тасгийн даргад* уулын ажлын төлөвлөгөө хүлээн авах ажил хариуцсан мэргэжилтэн танилцуулна.

6. Уулын ажлын төлөвлөгөөтэй танилцаж байгаа холбогдох мэргэжилтэн, албан тушаалтан нь *энэхүү зааварт* заасны дагуу холбогдох бүлгүүдэд тусгагдсан асуудлууд, хавсралт материалтай танилцан, танилцах хуудсанд танилцсан ажлын тухай өөрт ноогдсон хэсэгтээ тодорхой бичилт хийж, огноог тавин, гарын үсэг зурж баталгаажуулснаар, дараагийн мэргэжилтэн, албан тушаалтанд хүлээлгэн өгнө.

7. Уулын ажлын төлөвлөгөөтэй танилцаж байгаа Нүүрсний хэлтсийн мэргэжилтнүүд нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэмжээ, ашиглах арга аргачлалд өөрчлөлт хийхийг хориглоно.

8. Мэргэжилтэнүүд уулын ажлын төлөвлөгөөг хүлээн авсанаас хойш ажлын 2 өдрөөс хэтрэхгүй хугацаанд танилцаж хяналтын хуудсанд холбогдох тэмдэглэл, шүүмж, зөвлөмжийг бичсэн байна.

9. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлж байгаа төлөвлөгөө нь “Уулын ажлын төлөвлөгөө, тайлан хүлээж авах” дотоод зааврын шаардлагыг хангахгүй бол уулын ажлын төлөвлөгөө, тайлан хариуцсан

мэргэжилтэн дотоод хяналтын хуудсаар тухайн аж ахуйн нэгжид буцаан хүлээлгэн өгнө.

10. Уулын ажлын төлөвлөгөөтэй холбогдох мэргэжилтнүүдийн танилцан гарын үсэг зурсаны дараа удирдах шатны ажилтнуудын шийдвэр бүхий тэмдэглэгээ хийж баталгаажуулснаар нүүрсний ашиглалтын тусгай зөвөөшөрл эзэмшигч аж ахуйн нэгжийн ажилтанд хүлээлгэн өгнө. Нүүрсний ашиглалтын тусгай зөвөөшөрл эзэмшигч аж ахуйн нэгж нь эцэслэн батлагдсан Уулын ажлын төлөвлөгөөний нэг хувийг төрийн захиргааны байгууллагад албан тоотын хамт ирүүлснээр тухайн жилийн Уулын ажлын төлөвлөгөөг хүлээн авсанд тооцно.